



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ**

2017 оны 10 сарын 19 өдөр

Дугаар 12/28

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.8 дахь заалт, 33 дугаар зүйлийн 33.11 дэх хэсгийг үндэслэн Хууль зүйн болон Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлаар Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэлийг хэлэлцэж байгаатай холбогдуулан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай, Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулиудын хэрэгжилтэд хяналт шалгалт хийх, холбогдох санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Ажлын хэсгийн ахлагч:

Н.Оюундарь -Улсын Их Хурлын гишүүн

Гишүүд:

Ж.Батзандан -Улсын Их Хурлын гишүүн
Г.Мөнхцэцэг -Улсын Их Хурлын гишүүн
Б.Саранчимэг -Улсын Их Хурлын гишүүн
Б.Ундармаа -Улсын Их Хурлын гишүүн
Ц.Цогзолмаа -Улсын Их Хурлын гишүүн
Д.Цогтбаатар -Улсын Их Хурлын гишүүн

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:

Ж.Лхамрагчаа -Улсын Их Хурлын Тамгын газрын Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн референт


2. Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх ажлын дэд хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Ж.Бямбадорж -Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга
П.Оюунчимэг -Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн
Г.Эрдэнэбат -Улсын Ерөнхий прокурорын орлогч
Б.Энхбаяр -Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд
Г.Өнөрбаяр -Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга
Л.Нямгэрэл -Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны дарга

О.Алтансүх	-Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга
Д.Батчулуун	-Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга
Д.Энхжаргал	-Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн тэргүүн
Б.Баасандорж	-Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх
Л.Лхагвасүрэн	-Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх
Г.Баяртуяа	-Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны ажлын албаны зөвлөх
Б.Хонгорзул	-Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны зөвлөх
М.Отгон	-Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны референт

3.Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх чиглэлээр холбогдох байгууллагаас мэргэжлийн хүмүүсийг оролцуулж ажиллуулахыг ажлын хэсгийн ахлагч /Н.Оюундары/-д зөвшөөрсүгэй.


ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Ш.РАДНААСОД

УХА0316

НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Д.ЭНХ-АМГАЛАН

УХА0316